

М.БАТМӨНХ- ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН 8021 ДҮГЭЭР
ДАМЖААНЫ СУРАЛЦАГЧ, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Д.ТҮМЭНДЭЛГЭР-ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
УУПБ-ИЙН ДЭД ПРОФЕССОР, ЦАГДААГИЙН ХОШУУЧ

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХУУЛЬ БУС ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Товч агуулга: Зах зээлийн нийгэмд шилжсэнээр хувийн эмнэлэгүүд олноор байгуулагдан шинжилгээ, оношлогоо хийгдэж байгаа эмнэлгийн багаж хэрэгслийн баталгаанд эргэлзэх байдал иргэд, олон нийтийн дунд бий болж, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, ниймийн цахим сүлжээгээр баталгаагүй эм, био бэлдмэл хэрэглээд хордсон гэсэн мэдээлэл олноор гарч, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Түлхүүр үгс: хүний аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал, эмийн аюулгүй байдал, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал.

Key words: personal security, health security, medicine security, medical equipment security.

ОРШИЛ

Ер нь улс орнууд аюулгүй байдал хэмээх ойлголтыг бүхий л улсын хил хязгаарт заналхийлэлтэй холбон, зэр зэвсгийн хүчийг зузаатгах, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, хүн амын удмын санг хамгаалах, мөн хоол хүнс, экологи, соёл зэрэг салбар асуудлын хүрээнд авч үзэж ирсэн. Харин 1994 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс аюулгүй байдлын цөм нь улс гүрэн биш, хувь хүн байх¹ учиртайг онцолсноор “Хүний аюулгүй байдал” өнөөдөр дэлхийн хэмжээний бодлогын тулгуур үзэл баримтлал болжээ.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн² гэж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан.

Иймээс “Хүний аюулгүй байдал”-ыг хангахад **хууль бус эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл хэрхэн нөлөөлөх болон** энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн золиос болохоос урьдчилан сэргийлэх нь чухал байна.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЙЛГОЛТ

Хүн бол аливаа үндэстний гол баялаг юм.³ Хөгжлийн үр шимээс энгийн ард иргэд хожиж, үр шимийг нь хүртэж байх ёстой. “Хүн бол бүхний хэмжүүр” гэсэн үзэл санаанаас улбаалан, “Хүн бол хөгжлийн хэмжүүр” гэж үзэж болно.⁴ Аливаа үндэстний баялаг нь хүн учраас хөгжлийн зорилго нь хүн ардаа эрүүл энх, бүтээлчээр урт удаан амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.⁵

1. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр 1994.

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он.

3. UNDP, “Human Development Report 1990: “Defining and measuring Human Development”, p. 9.

4. <http://www.president.mn>. 2005 оны УИХ-ын намрын чуулган дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үгнээс.

5. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”, 1990 он.

Өөрөөр хэлбэл, хөгжлийн үр шимээс иргэд хүртэж байх ёстой гэдэг утгаараа улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл нь тухайн улсад амьдарч буй хувь хүмүүсийн хөгжлийн түвшин байдаг байна.

Хүмүүс мэдээлэл хүртэх бололцоо, хоол тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах, амар амгалан аж төрөх нөхцөл бий болгох, гэмт хэрэг, биеийн хүчирхийллээс хамгаалагдах, улс төр, соёлын эрх чөлөө эдлэх, олон нийтийн үйл хэрэгт оролцох гэх мэт тэр бүр ил тод харагддаггүй, орлогын болон өсөлтийн хэмжигдэхүүнээр илэрхийлэгддэггүй сонголтыг хийдэг. Өөрөөр хэлбэл, хөгжлийн зорилго нь хүмүүсийн урт удаан, эрүүл, бүтээлч амьдрах нөхцөлийг бий болгоход оршиж байгаа юм.

Өнөөгийн ертөнцийн аль нэг улс оронд амьдарч буй хувь хүн өдөр тутмын амьдралдаа улс гүрнүүдийн хоорондын харилцаа, дэлхий дахины үйл явдлаас илүүгээр өөрийн амь нас, эрүүл мэнд, орон гэр, орлогын тухайн нөхцөл дэх баталгаа, үр хүүхдийнхээ ирээдүйг чухалчилдаг. Түүнчлэн хүн төрөлхтний амьдралын өнөөгийн хэв маяг нь хувь хүний түвшинд асуудлыг авч үзэхгүйгээр улс үндэстний, эсвэл хүн төрөлхтөний аюулгүй байдлыг хангах бололцоогүй болгож байна.

Үндэсний аюулгүй байдал нь хувь хүний амьд явах, эрхэмсэг оршихуйн аюулгүй байдлын нэг урьдчилсан нөхцөл мөн боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Улс орон хэдийгээр баян, хүчирхэг байлаа ч энэ нь тухайн улс орны хүн ам айх аюулгүй, баян чинээлэг байхын баталгаа биш. Засгийн газрын үүрэг нь хувь хүн өөрийгөө аваад явах чадвартай болгох төдийгүй, боломжоо зүй бус хориг хязгаарлалтгүй хөгжүүлэх суурь орчинг бий болгоход оршино.

Аюулгүй байдлын үзэл баримтлалыг олон жилийн туршид явцуу тухайлбал, гадаадын түрэмгийллээс нутаг дэвсгэрээ хамгаалах байдлаар ойлгож хэрэгжүүлсэн нь ард түмнээс илүү улс оронд хамааралтай болгон өдөр тутам айх аюулгүй амьдрах гэсэн хүний зүй ёсны хүсэл эрмэлзлэлийг орхигдуулсан байх талтай. Хүмүүс өвчин эмгэг, өлсгөлөн, ажилгүйдэл, гэмт хэрэг, нийгмийн сөргөлдөөн, улс төрийн хэлмэгдүүлэлт, байгаль орчны бохирдуулалт зэргээс хамгаалагдсан байхыг хүсдэг. Өөрөөр хэлбэл, ихэнх хүмүүсийн хувьд аюулгүй байдлын таагүй мэдрэмж нь дэлхий дахины сүйрлийн аюулаас бус, өдөр тутмын амьдралдаа сэтгэл зовнисон байдлаас урган гарч байна.

Хүн амьдрах орон байр, өмсөх хувцас, эрхлэх ажлын төлөө санаа зоволгүй, өвчин эмгэг, гэмт аюулаас хол эсэн мэнд байж, үр хүүхдээ өсгөн бойжуулж, урт удаан аз жаргалтай амьдрахыг эрхэмлэдэг учраас хүний аюулгүй байдал нь хүний хэвийн амьдралын гол чанарын нэг болон тавигддаг.

Хүний аюулгүй байдал нь ядуурал, тэгш бус байдал, хөгжлийн ялгаатай түвшин, улс төрийн тогтворгүй байдал зэрэгтэй холбогдон гарах зөрчил, хүчирхийлэл, гэмт халдлага, дарамт, шахалтаас хувь хүмүүс хамгаалагдсан байхыг шаардах бөгөөд эдгээрээс урьдчилан сэргийлэх нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс болно.

Дутагдах, гачигдах зүйлгүй байх нь хүний аюулгүй байдлын нэлээд олон талт хандлагын илрэл бөгөөд өлсгөлөн, өвчин, байгалийн гамшиг, осол зэрэг өргөн хүрээний асуудлыг хамруулан үздэг. Дээрх хүчин зүйлүүд нь хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, дайн, удмын сангийн өөрчлөлт, алан хядах ажиллагаа зэргээс ч илүүтэйгээр олон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулсаар байна.

Улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтийн зорилго нь өнөө хийгээд хойч үеийн хүний сайн сайхан байдал, сэтгэл хангалуун амьдралын төлөө байх ёстой гэж үздэг хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлалд хувь хүний болон улс орны аюулгүй байдал нь зэвсгийн хүчээр бус, тогтвортой хөгжлөөр хангагдах учиртай гэдгийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 1994 онд гаргасан Дэлхийн хүний хөгжлийн илтгэлд тэмдэглэжээ.

Энгийнээр тодорхойлбол “Айх аюулгүй, өвдөх өвчингүй, дутагдах гачигдах зовлонгүй, урт насалж, удаан жаргах нь хүний аюулгүй байдал” юм.⁶

Улс орнууд айх аюулгүй байх гэсэн эхний асуудалд ихээхэн анхаарал хандуулж байна. Дутагдах, гачигдах зүйлгүй байх нь тухайн улсын зөв бодлого, үйл ажиллагаа, улмаар хөгжлийн түвшинтэй харилцан уялдаатай. Тухайлбал:

Улс орны эдийн засаг хэдий хэмжээгээр өснө, тэр хэмжээгээр ард түмний орлого, баялаг нэмэгдэж байх ёстой байтал хөгжлийн үр шимээс зөвхөн тодорхой хэсэг нь хүртэх явдал түгээмэл байсаар. Орлогын, хүйсийн, эрх мэдлийн тэгш бус байдал нь зөрчил үүсэх, хурцдах, улмаар аюулгүй байдал алдагдахын суурь болсоор байна.

Сүүлийн үед хүний аюулгүй байдал нь улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, нийгэм, төрийн аюулгүй байдал төдийгүй жирийн иргэдэд ч хамааралтай болж байна.

Хүний аюулгүй байдлын орчин үеийн ойлголт нь аюулгүй байдлын талаарх уламжлалт ойлголтоос ялгаатай.

Хүний аюулгүй байдлын ойлголтыг илүү тодруулах дөрвөн шинж чанар бий. Үүнд:

1. Хүний аюулгүй байдлын тухай ойлголт нь түгээмэл шинж чанартай. Энэ нь дэлхий дээр оршин тогтнож байгаа бүх улс орон, бүхий л хүн төрөлхтөнд хамаатай асуудал юм. Ажилгүйдэл, гэмт хэрэг, агаарын бохирдол, хар тамхи, хүний эрхийг зөрчих зэрэг түгээмэл хүчин зүйлүүд дэлхийн аль ч улс оронд ажиглагдаж хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөөр байна.

2. Хүний аюулгүй байдал нь харилцан хамааралтай шинжтэй. Дэлхийн аль нэг хэсэгт хүний аюулгүй байдалд аюул занал учирвал энэ нь дэлхийн бүх орнуудад тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөг үзүүлж байдаг. Өлсгөлөн, өвчин, байгаль орчны бохирдол, мансууруулах бодисын худалдаа, алан хядах ажиллагаа зэрэг нь тухайн улс үндэстний хил хязгаараас хальж, хор уршиг нь дэлхий нийтэд ямар нэгэн байдлаар сөрөг нөлөө үзүүлдэг.

3. Хүний аюулгүй байдлыг хангахад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь учирч болзошгүй аюулыг илрүүлэх, эхний шатанд арилгахад ихээхэн ач холбогдолтой байдаг.

4. Хүн төрөлхтний аюулгүй байдал нь хүнээс өөрөөс нь хамаарах шинжтэй. Өөрийнхөө болон бусдын төлөө байх чадавхитай, аюулгүй байдлыг хангахад гар бие оролцдог байхаас хүний аюулгүй байдал шууд хамаарна.

Хүний аюулгүй байдал нь өдөр тутмын амьдралаа хэвийн үргэлжлүүлэх, ялгаварлан гадуурхагдахгүй байх асуудлуудтай ч нягт холбоотой. Үүнээс үзэхэд хүний аюулгүй байдал нь хүний хөгжлийн баталгаа, түүний урьдач нөхцөл нь болдог.

Хүний хөгжил ба хүний аюулгүй байдал нь хоорондоо дараах байдлаар уялдаатай.

Үүнд:

Хүн төвтэй: Хөгжлийн зорилгыг хүн гэж үзэж, энэ хүрээнд аюулгүй байх, суурь үйлчилгээгээр хангагдах, чөлөөт сонголт хийх зэрэг хүний сайн сайхан амьдралын бүхий л бүрэлдэхүүнийг хамруулан тодорхойлдог.

Олон талыг хамарсан: Хүний сайн сайхан байдлыг бий болгогч материаллаг ба материаллаг бус байдлыг хамрах учир олон талын хэмжүүртэй.

Ядуурал, тэгш бус байдлыг авч үздэг: Хүний хөгжил нь хүний сонголтын хүрээг өргөжүүлдэг бол ядуурал нь хүний боломж, сонголтыг олон талаар хязгаарладаг. Энэ утгаар ядуурал, тэгш бус байдал нь хувь хүний түвшинд эмзэг байдлыг бий болгогч үндсэн хүчин зүйл болдог байна.

Хүний аюулгүй байдлын ойлголт нь хүмүүс өөрсдийнхөө сонголтыг чөлөөтэй, аюулгүй байдлаар хийх, өнөөдрийн эзэмшиж байгаа бүхэндээ маргааш эзэн нь байх агуулгатай.

Хүн төрөлхтний оюун ухаан, эрдэм мэдлэг, шинжлэх ухаан технологийн хөгжлийн хэрээр чөлөөт байдал гүнзгийрсээр байгаа нь хүний аюулгүй байдлыг хангах нэгэн нөхцлийг бүрдүүлж байна. Хүний аюулгүй байдал нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий дараах долоон үндсэн чиглэлтэй. Үүнд:

1. Хувийн аюулгүй байдал,
2. Хүй элгэний аюулгүй байдал,
3. Эрүүл мэндийн аюулгүй байдал,
4. Хүнсний аюулгүй байдал,
5. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал,
6. Эдийн засгийн аюулгүй байдал,
7. Улс төрийн аюулгүй байдал зэрэг болно.

Эдгээрээс эрүүл мэндийн буюу хүний аюулгүй байдалд **хууль бус эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл хэрхэн нөлөөлж байгааг авч үзэх болно.**

Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн зарим асуудал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1-д “Цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна”, мөн 3.4-д “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж заасан.

Улс орны оршин тогтнох үндэс бол хилийн дархан байдал, батлан хамгаалах чадвараас гадна хүн амын эрүүл мэнд бөгөөд эрүүл мэндийн аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд хүн амын дундах өвчлөлийг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, иргэдэд чанарын шаардлага хангасан, баталгаатай эмийн сан, эмнэлгийн тоног төхөөрөмж бүхий байгууллагаар үйлчлүүлэх талаар сургалт сурталчилгааг харамгүй явуулах явдал юм.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдарч хөгжих боломжийг хангахад эм, эмнэлгийн хэрэгслийн баталгаагүй байдлаас шалтгаалах 3 үндсэн эрсдэл байна. Үүнд:

1. Иргэд маань өөрсдөө баталгаатай эмийн сан, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлдэггүй;
2. Эмийн сан болон эмнэлгийн байгууллага нь баталгаатай нийлүүлэгчээс стандартын шаардлага хангасан эмийг, эмнэлгийн хэрэгслийг тодорхой хяналт дор авч, түгээн борлуулдаггүй, борлуулсан эм, эмнэлгийн хэрэгсэл нь тоо ширхэг, бусад байдлаараа тухайн байгууллагын улсад тушаадаг татвар, бусад шимтгэлээр баталгаажиж чаддаггүй;
3. Тухайн эм, эмнэлгийн хэрэгслийг бэлтгэж, ханган нийлүүлж буй байгууллага олон улсын стандартыг хангасан чанартай, баталгаажсан эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэдэг, импортлон оруулж ирдэг байх. Үүнд төр, тэр дундаа хуулийн байгууллагын зохих албад хяналтаа тогтмолжуулах нь чухал юм.

Эмийн тухай хуулийн 3.1.1-д "эрүүл мэнд" гэж "хүн өвчин, змгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг" заасан бол,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд: 3.1.1 ."эм" гэж "хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг"; мөн хуулийн 3.1.2-т "биобэлдмэл" гэж "хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар амьд бие, бие махбодь, түүний эд, эсээс болон лабораторийн аргаар гаргаж авсан бүтээгдэхүүнийг"; түүнчлэн 3.1.5- р зүйлд "эмнэлгийн хэрэгсэл" гэж "хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, сувилах болон бие махбодийн бүтэц, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг туслах зориулалтын эд зүйл"-ийг байхаар хуульчилсан байна.

ХУУЛЬ БУС ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛД МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХИЙСЭН СУДАЛГАА

2016 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас явуулсан нэгэн шалгалт, судалгаагаар: Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрүүд нь давхардсан тоогоор 411 нэрийн шахмал, галейн, үрэл, тарилга эм, 695 нэрийн уламжлалт эм, 9 нэрийн биобэлдмэл, 27 нэрийн биологийн идэвхит бэлдмэл, гурван нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 31 нэрийн ариутгалын бодис, нийт 1176 эм, бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг.

Гэтэл эм үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн 22 эмийн үйлдвэрийн 838 нэрийн эм, биологийн идэвхит бүтээгдэхүүн улсын бүртгэлгүй нь тогтоогджээ. Энэ нь нийт үйлдвэрлэдэг 1176 эм, бүтээгдэхүүний 71.3 хувийг эзэлж байгаа судалгаа гарчээ.⁷

Эдгээр эм хэрэгслийн бие мах бодид үзүүлэх үйлчилгээ, үг дагавар нөлөөллийн онцлог байдлыг харгалзан ангилахад, 5 нэрийн тарилгын эмийн хэлбэр, нэг нэрийн шархны цацлага, 16 нэрийн антибиотек эмийн хэлбэр, 4 нэрийн эмийн сангийн бэлдмэл, 18 нэрийн галейны бэлдмэл, 9 нэрийн тосон түрхлэг, 3 нэрийн нунтаг, 10 нэрийн үрэл, 11 нэрийн зэхмэл, 33 нэрийн шахмал, капсул гэх мэт 112 нэрийн эм, биологийн идэвхит бүтээгдэхүүн, 572 нэрийн уламжлалт эм улсын бүртгэлд бүртгэгдээгүй гэсэн нь үнэхээр аймшигтай тоо бөгөөд эдгээрээс тарилгын эм, антибиотек, эмийн сангийн дотоод бэлдмэлүүд нь маш өндөр эрсдэлтэй гэдгийг мэргэжилтнүүд анхааруулсаар байна.

Мөн дээрх эм, эмийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгүүлээгүй 22 үйлдвэрийн үйл ажиллагааг зөвхөн бүтээгдэхүүнээ бүртгүүлэх хүртэл хугацаанд үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан нь хачирхалтай байна.

Мэргэжлийн хяналтын байгууллага нь 2010 оноос хойш анхааруулсаар байхад үл тоомсорлон, ард иргэд нь хэрхэн хордсон эсэх нь ч тодорхойгүй, хууль бус эм, эмнэлгийн бүтээгдэхүүн хэрэглэгдсээр л байна.Төрийн байгууллагуудын нэгдсэн хяналт, хуулийн хэрэгжилт хангалгүй байгаа эндээс илэрхий харагдана.

Бид нийгэмд ил цагаан гарч буй гэмт хэрэг, зөрчил нэг бүртэй тэмцэж байгаа хэдий ч хүний зовлон дээр ноёлсон, "эм" хэмээх энэ буянтай ч юм шиг, эдгээгээд байгаа, улам хүндрүүлээд байгаа нь үл мэдэгдэх эм бэлдмэл зохих зөвшөөрөлгүй үйлдвэрлээд байгаа эм,

7. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2016 оны статистек мэдээлэл.

эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр гэх тодотголтой эрхэмүүдийн үйл ажиллагаатай хэрхэн тэмцэх нь тодорхойгүй хэвээр.

Энэ талаарх ойлголт, мэдээлэл багатай иргэдийн зүгээсүзэхэд үндэсний эм үйлдвэрлэгчид “хүн ардынхаа эрүүл энхийн төлөө ажиллаж, үйлдвэрлэж байгаа” мэт боловч цаана нь чанар, баталгаа хангагдаагүйгээс үүдэн гарах /нүдэнд бодитоор үл үзэгдэх/ үр дагаварыг анзаарахгүй, хайнга байдал нь өвчлөл хүндрэх, цаашлаад үхлийн шалтгаан болсоор бие, эрхтэнээрээ туршилт болж хохирсоор, хууль хяналтын болон бусад байгууллагаас шалтгаан, нөхцлийг тогтоож, хяналт тавихгүй явсаар, эцсийн дүндээ иргэд хохирсоор, эрүүл, аюулгүй амьдрах баталгаагаа алдсаар байна.

Төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл олгохдоо ерөнхий нэршилээр буюу эм үйлдвэрлэх, биобэлдмэл үйлдвэрлэх, уламжлалт эм үйлдвэрлэх гэх мэт эсвэл шахмал, үрэл, галейн, тарилгын эм үйлдвэрлэх зэргээр бүх хэлбэрийг үйлдвэрлэхээр зааж өгсөн нь эмийн замбараагүй үйлдвэрлэл явуулах нөхцлийг бүрдүүлж байна гэж дүгнэхээр байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, үйлчилгээний зөвшөөрөл олгогдоод, дараагийн хяналт орхигдсон, эсвэл нөгөө л авлига, танил тал, бусад нөлөөлөл. Хяналтын арга, хэлбэр сайжирвал, иргэдийн эмийн зөв хэрэглээ, баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийн үйлчилгээ авах нөхцөл, боломж бүрдэх юм.

Энэхүү судалгааны явцад 2016 оны байдлаар эмийн үйлдвэрүүдийн 28.6 хувь нь эмийн түүхий эдийг эмийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй, 24 хувь нь тухайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө эмийн түүхий эд, туслах бодисыг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулдаггүй зөрчил гарч байсан, одоо ч байсаар байж болзошгүй байдал тогтоогдсон. Тухайлбал, “Нью Аюур вед” эмийн үйлдвэр нь чанарын хяналтын лабораторигүй байсан, эмийн үйлдвэрүүдийн 69.9 хувь нь урвалж бодисын хүчинтэй хугацаа, засварын коэффициентийг дахин тогтоох огноо, хадгалах нөхцөл, урвалжийг бэлтгэсэн огноо, ажилтны гарын үсэг бүхий шошгожуулалтгүй, олонх үйлдвэр мэргэшсэн ажилтангүй байсан нь шалгалтаар илэрчээ. Мөн “Монос”-ын эмийн санд худалдаалагдаж байсан “Фенобарбитал” гэх эмнээс 16 хүүхэд хордсон, уг эм улсын бүртгэлд бүртгэгдээгүй байсан байна.

Иргэдийн дийлэнх олонх нь толгойн өвдөлт намдаах, хамрын ханиад эмчлэх хамгийн найдвартай арга бол эм гэдэгт итгэдэг. Тиймдээ ч эмчид хандахаасаа илүүтэй хамгийн ойрын эмийн сангаас шаардлагатай гэж үзсэн эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг аваад хэрэглэхдэг зуршил, хандлага давамгайлсан байтал, эмийн түүхий эдийг лабораторид шинжлүүлдэггүй, эмийн үйлдвэрийн шаардлага хангахгүй нөхцөлд үйлдвэрлэгдсэн олонтаа тул өөрийн эрхгүй айх, болгоомжлолд хүргэж байна.

Монгол Улс дахь хууль бус эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах түгээх гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Монгол Улсад эм, эмнэлгийн хэрэгсэл хилээр нэвтрүүлэх зөвшөөрөлтэй Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Өлгий, Цагаануур зэрэг зургаан боомт бий.

ОХУ-ын эмийн зах зээлийн эргэлтийн 30 гаруй хувийг хуурамч эм эзэлдэг гэсэн судалгаа байдаг бөгөөд тус улсаар дамжин чанаргүй эм болон хуурамч эм нэвтрэх үүд хаалга байнга нээлттэй байна. 1994 онд Вьетнам Улсаас импортолсон хуурамч эм “Пенициллин”-ыг илрүүлж байсан. 2001 онд их хэмжээний хуурамч “витамин В комплекс”-ыг Буянт-Ухаа боомтоор оруулах гэж байхад нь саатуулан устгасан, мөн 2019 онд “Буянт-Ухаа” боомтод

хийсэн шалгалтаар Бээжин-Улаанбаатарын чиглэлийн ОМ-224 онгоцоор ирсэн зорчигчоос “Эрдэнэбүрэн” компанийн эмийн үйлдвэрийн нэр, лого, хаяг, шошгыг ашиглан БНХАУ-д хуурамчаар үйлдвэрлэсэн хорин мянган ширхэг эмнэлгийн хөвөн савлах зориулалтын мөнгөлөг гялгар уутыг хууль бусаар оруулах гэж байхад нь илрүүлсэн зэрэг хэрэг, зөрчлүүд бүртгэгдсэн байна. Мөн төрийн албан хаагчийн шүүхээр таслан шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тохиолдоос дурьдвал Эрүүл мэндийн яамны нэгэн газрын дарга өөрийн хувийн компаниа тендерт ялуулж улмаар чанаргүй эмнэлгийн машин, техник хэрэгсэл нийлүүлж дундаас нь мөнгө завшдаг хэрэг гарч шүүхээр шийдвэрлэгдэн 3 жил хорих ял шийтгүүлжээ.

Түүнчлэн Эмийн тухай хуульд “...худалдаж борлуулах зорилгоор эм сурталчлахыг хориглоно” гэж заасан. Гэтэл орой бүр телевизийн дэлгэцээр эмийн сурталчилгаа гарсаар. Өндөр хөгжилтэй орнуудад антибиотикийн төрлийн эм болон бусад эмийг эмчийн жороор олгодог байтал манайд энэ төрлийн хяналт сул байгаагаар барахгүй МХЕГ-аас манай улсад бүртгэгдсэн эм мөн эсэхийг шалгах аас хэтрэхгүй байдалтай байна.

Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх гэмт хэргийн шалтгаан буюу дээрхи эм, биобэлдмэл үйлдвэрлэгдэн борлуулагдаж буй шалтгаан нь:

1. Хямд үнэ
2. Өнчин эмийн хэрэгцээ /өнчин эм гэж ховор тохиолддог өвчнийг эмчлэхэд болон улсын хэмжээгээр харьцангуй бага хэрэглэдэг эмийг хэлдэг/
3. Ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин, мэдлэггүй байдал
4. Аргагүйдэл /өөр яахаа мэдэхгүй байх/ зэргээс шалтгаалж эрэлт үүсэж байгаатай хэн ч маргахгүй.

Энэ эрэлтээс гадна дэлхий нийтээр олон хүний анхаарлыг татаж буй таргалалт, болон бусад төрлийн өвчин эмгэг, гоо зүйн таашаал эдлэх мэдрэмж зэргээс шалтгаалж хаана үйлдвэрлэгдсэн нь мэдэгдэхгүй, ямар үр дүнтэй нь лабораторын туршилт, судалгаагаар тогтоогдоогүй эмийг бусдын хүсэлтэд тохируулан зар тарааж худалдах, урлаг спортын олны танил хүмүүсээр сурталчуулан захиалга авч түүний эрэлтэд үндэслэн хилээр хууль бусаар оруулж ирэх байдлаар явагдаж байгаа байдал амьдралд харагддаг.

Хуурамч эм борлуулагч нартай тэмцэнэ гэж ярьдаг ч энэ нь амьдрал дээр хэрэгжихгүй байгааг мэргэжлийн байгууллагаас гаргасан судалгаа харуулж байна.

Манай улсын эмийн бүртгэлд 1500 гаруй эм байдаг ба дотооддоо эмийн хэрэгцээнийхээ 30 орчим хувийг хангадаг, бусад нь гадны импорт юм байна. Тарилга, шахмал антибиотикийг дотооддоо үйлдвэрлэж, бусад эм тариаг гаднаас импортлодог. Импортын эм, тариа, бэлдмэлийг шинжлэх лабораторийн хүчин чадал муугаас хяналт суларчээ. Учир нь эмийн найрлаган дахь идэвхийг үздэг лаборатори Монгол Улсад байдаггүй юм байна.

Эм худалдах тусгай зөвшөөрөлгүй иргэд баталгаагүй эм оруулж ирэн хар зах дээр худалдах явдал хэрээс хэтэрсэн нь Монгол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй үндэсний аюулгүй байдалд маань ч нөлөөлж байна.

МХЕГ, Эрүүл мэндийн яам, Стандартчилал хэмжил зүйн газар хамтран эмийн бүтээгдэхүүний чанар стандартыг шалгах аар үзлэг, шинжилгээ хийдэг боловч энэ нь нөлөөгүй байна.

Өмнө нь дурдсан 2016 онд хийсэн шалгалтаар 170 орчим эмийн бүтээгдэхүүний ердөө 15.9 хувь нь л чанарын шаардлага хангажээ. Энэ нь манайд үйлдвэрлэсэн эмийн 50 орчим хувьд нь хийсэн шалгалт. Өөрөөр хэлбэл, та бидний түгээмэл хэрэглэдэг эмний 80 гаруй хувь нь эм биш хор болж байна гэсэн үг.

ДҮГНЭЛТ

Хүний аюулгүй байдлыг хангах нь хөгжлийн зорилго төдийгүй тухайн улс орны хөгжлийн үр дүн байна. Мөн хүний аюулгүй байдлыг хангахад нэг талаас төрийн, нөгөө талаас хувь хүний өөрийнх нь үүрэг хариуцлагыг тодорхой байлгах нь чухал.

Иймд хилээр оруулж ирж байгаа элдэв гадаад бичигтэй, тураадаг, таргалуулдаг, хөөрхөн болгодог зэргээс нь эхлээд бүх төрлийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүнд тавих хяналтаа шат шатандаа нэмэгдүүлэх, мөн дотоодын үйлдвэрлэгчдээ хянаж чаддаг болох, үйлдвэрлэж байгаа, шинэ гаргаж авсан эмүүдийг улсын бүртгэлд бүртгүүлдэг хариуцлагын өндөр механизмыг хэрэгжүүлэх /шууд үйлдвэрлэл, үйлчилгээний зөвшөөрлийг цуцлахаас эхлээд/, иргэд зөвшөөрөгдсөн цэгээс, эмчийн жороор баталгаажсан чанартай эмээ авч хэрэглэж дадахгүй бол хүний эрүүл, аюулгүй байх эрх хөндөгдсөн хэвээр үргэжлэх нь.

Ер нь улсын дотоод аюулгүй байдлын цөм нь хүний аюулгүй байдал юм бол, хүний аюулгүй байдлыг хангахад төрийн аливаа нэг салбарын хяналт доголдож болохгүй гэдэг санааг илэрхийлж, хэрэв доголдвол учир ч болох нь аюул нь төсөөлж баршгүй юм гэдгийг онцгойлон “эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал” гэх нэгж сэдвээр тодорхойлж, цөөн хүн амтай манай орны хувьд баталгаат эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох явдалд онцгой анхаарч, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илэрхийлэхийг зорилоо.

САНАЛ

Эмийн сангуудад хийсэн шалгалтаар илэрсэн хүлээн авсан жорын маягт шаардлага хангахгүй, эмнэлгийн нэр, хаяг, тэмдэггүй, огноо болон эмийн нэрийг латинаар бичээгүй, эмчийн нэрийг бичиж, хувийн тамга дараагүй гэх мэт түгээмэл зөрчлүүдийг нэн даруй таслан зогсоох.

Дотоодын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг чанаржуулах нь үүсэх зарим эрсдэлээс сэргийлж чадах нөхцлийг бүрдүүлэх зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг, Очирбат Н. Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал. УБ., 2000 он
2. Удирдлагын Академийн Нийгмийн удирдлагын тэнхим. Хүний хөгжлийн хичээлд зориулсан нэмэлт унших материалууд. УБ., 2006 он
3. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл 1997. УБ., 1997 он
4. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл 2000. УБ., 2000 он
5. UNDP. Human development report 1994. Oxford university press. 1994
6. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2016 оны статистик мэдээлэл.
7. Цахим эх сурвалжууд.